



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Тооллого явуулах тухай

Монгол улсын "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх хэсэг, "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, "Төрийн өмчийн тухай" хуулийн 70 дугаар зүйлийн 70.1, 70.2 дэх хэсэг, 71, 72, 73-р зүйл, Байгууллагын "Өмч хамгаалах зөвлөл"-ийн ажиллах журмын 3.4, 3.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын үндсэн хөрөнгө, эд аж ахуйн хадгалалт хамгаалалт түүнд тавигдах хяналт шалгалтын ажлын хүрээнд 2025 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллогын комиссыг байгуулж, 2025 оны 06 дугаар сарын 02-ны дотор дүнг нэгтгэн хүргүүлсүгэй.

2. Тооллого явуулах комиссын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай.

Тооллогын комиссын дарга
Гишүүд

Х.Бямбасүрэн
Э.Тулга
Г.Билгүүн

3. Үндсэн хөрөнгө, эд аж ахуйн тооллогыг үнэн зөв тоолон бүртгэж, тайлан мэдээг 2025 оны 06 дугаар сарын 02-ны дотор удирдлагад танилцуулж, тайлагнан ажиллахыг тооллогын комиссын дарга Х.Бямбасүрэнд үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТХҮҮ